

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр, Баасан гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга 0

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

1.Нийтийн өргөдлийн тухай 3-4

2.Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэх /Нэмэгдсэн өртгийн албан татварын хэрэгжилтийг хангуулах, татвар ногдуулалт болон төлөлт, тайлагналтыг сайжруулах, эдийн засгийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад бодит дэмжлэг үзүүлэх зорилгоор нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар зэрэг татвартай холбоотой эрх зүйн орчин, татварын тогтолцоонд үнэлэлт, дүгнэлт өгч, дүн шинжилгээ хийж, татварын шинэчлэлт хийх үүрэг бүхий/ 4-6

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 11 дүгээр сарын 10-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 20 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Д.Өнөрболор;

Чөлөөтэй: Л.Мөнхбаатар;

Тасалсан: Г.Амартүвшин, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Б.Жавхлан,
Б.Чойжилсүрэн.

Нэг.Нийтийн өргөдлийн тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын Тамгын газраас 2023.11.07-ны өдөр ирүүлсэн албан бичгийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Уг асуудлыг 11 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэх /Нэмэгдсэн өртгийн албан татварын хэрэгжилтийг хангуулах, татвар ногдуулалт болон төлөлт, тайлагналтыг сайжруулах, эдийн засгийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад бодит дэмжлэг үзүүлэх зорилгоор нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар зэрэг татвартай холбоотой эрх зүйн орчин, татварын тогтолцоонд үнэлэлт, дүгнэлт өгч, дүн шинжилгээ хийж, татварын шинэчлэлт хийх үүрэг бүхий/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ажлын хэсгийн санал, дүгнэлт болон үүнтэй холбогдуулан гаргасан “Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: “Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 12 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 11 цаг 32 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим,
11 цаг 20 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн энэ өглөөний мэндийг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг та бүхэнд юуны өмнө танилцуулъя.

Одонтуяа гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Баделхан гишүүн, Даваасүрэн гишүүн, Пүрэвдорж гишүүн, Хүрэлбаатар гишүүн, Батжаргал гишүүн, Раднаасэд гишүүн, Батсуурь гишүүн, Сандаг-Очир гишүүн нар хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд Төсвийн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдэж байна.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудлыг танилцуулна.

1 дүгээрт, хууль тогтоомжийн шаардлагыг хангаж, иргэдээс ирүүлсэн өргөдөл буюу нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын шимтгэлийг 50 хувь бууруулах нийтийн өргөдлийг хэлэлцэх гэдэг нэг ийм асуудал байгаа.

2 дугаарх нь, өмнө нь ирүүлсэн хууль тогтоомжийн шаардлагыг хангаж, 100 мянга гаруй иргэдээс ирүүлсэн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын 2 хувь

болоод түүнийг нэмэгдүүлэхтэй холбогдуулж, Төсвийн байнгын хорооноос ажлын хэсэг гаргасан байгаад байгаа. Энэ ажлын хэсэг зөвхөн нэмэгдсэн өртгийн албан татвар бол биш мөн дээрээс нь нэмж бусад энэ татварын эрх зүйн орчинтой холбоотой асуудлаар үнэлэлт дүгнэлт өгч, татварын тогтолцоо, эрх зүйн орчинд шаардлагатай тохиолдолд шинэчлэх саналаа танилцуулах ийм ажлын хэсгийг байгуулсан. Энэ ажлын хэсгийн зүгээс бид нар бас нэг Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2 дахь асуудал дээр танилцуулахаар ингээд оруулж ирж байна.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай, асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

1 дэх асуудал нь. Нийтийн өргөдөл буюу хууль тогтоомжийн шаардлагыг хангаж, Улсын Их Хурлын албан ёсны программ хангамж ди парламент буюу ди өргөдөл системээр дамжуулаад иргэн Шагжсийн Хүрэлтулгын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр гаргасан нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын шимтгэлийг 50 хувь бууруулах гэсэн гарчигтай нийтийн өргөдлийг 100 мянга ба түүнээс дээш тооны иргэд дэмжиж, энэ өргөдөл гаргасан байгаад байгаа.

Тэгээд үүнтэй холбогдуулж, Улсын Их Хурлын Тамгын газар болоод Улсын Их Хурлын даргын зүгээс манай Байнгын хороонд энэ асуудлыг шилжүүлсэн байгаа. Ингээд энэ нийтийн өргөдлийг дэмжиж, саналаа өгсөн иргэд буюу нийт 100 мянган иргэд дунд нийт 18-25 насныхан 29 хувь саналаа өгсөн, 26-35 насныхан 47,8 хувь өгсөн гэсэн. Дийлэнх ийм иргэд саналаа өгсөн ийм өргөдлийг ирүүлсэн байгаад байгаа.

Үүнийг албан ёсоор Төсвийн байнгын хороонд та бүхэнд бас танилцуулж байгаа. Ингээд манай Хууль тогтоомжийн хууль болоод Цахим бодлогын байнгын хорооноос гаргасан цахим систем ашиглан иргэдийн оролцоог хангах санал авах журмын хүрээнд энэ өргөдөл ирснээс хойших 14 хоногийн дотор холбогдох Байнгын хороо энэ асуудлыг авч хэлэлцэнэ гэсэн ийм зохицуулалт журамтай юм байна.

Төсвийн байнгын хороонд Улсын Их Хурлын Тамгын газраас 2023 оны 11 сарын 07-ны өдрийн албан тоот бичгээр хүрэлцэн ирсэн байгааг бас та бүхэнд сонордуулж, өнөөдрийн Байнгын хуралдаанд танилцуулж байгааг илтгэх байна.

Үүнтэй холбогдуулаад би бас 2 дахь асуудлыг нэгтгээд хэлэлцэх саналтай байгаад байгаа. Учир нь юу вэ гэхээр бид нар өмнө нь ирүүлсэн нэмэгдсэн өртгийн албан татвартай холбогдуулж, мөн татварын эрх зүйн орчныг тогтолцоог дүн шинжилгээ хийж үнэлэлт дүгнэлт өгөхтэй холбогдуулж ажлын хэсэг гаргасан. Тэгэхээр бас энэ ажлын хэсэг нэг талдаа энэ 11 сарын 07-нд ирүүлсэн өргөдлийг бас хамтад нь хэлэлцээд явах энэ асуудлаар хамтад нь шийдвэр гаргаад явах боломжтой гэж бид нар бас үзэж байгаа.

Ингээд нэг дэх асуудлыг бас хэлэлцүүлж дууслаа.

Ингээд 2 дахь асуудалдаа орцгооё.

1 дэх асуудалтай холбогдуулж асуулт, саналтай гишүүд байгаа юу? Алга байна. Ингээд эхний асуудлыг хэлэлцэж дууссан. Асуулт саналтай гишүүд алга байна. Ингээд эхний асуудлыг хэлэлцэж дууслаа.

11.28 цаг

2 дахь асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Төсвийн байнгын хорооны 2023 оны 11 сарын 01-ний өдрийн 10 дугаар тогтоолоор бид бүхэн ажлын хэсэг байгуулсан байгаа. Энэ ажлын хэсэг маань 2 үндсэн чиглэлтэйгээр арга хэмжээг авах байсан.

1 дүгээрх нь, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, татвар ногдуулалт болоод төлөлт, тайлагналтыг сайжруулах, эдийн засгийн ил тод байдлыг нэмэгдүүлэх гэдэг хүрээнд, 2 дахь нь, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад бодит дэмжлэг үзүүлэх зорилгоор нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар болоод аж ахуйн нэгжийн орлогын албан татвар зэрэг татвартай холбоотой эрх зүйн орчин татварын тогтолцоонд үнэлэлт, дүгнэлт өгч, дүн шинжилгээ хийн татварын шинэчлэл хийх саналаа Төсвийн байнгын хороо, Улсын Их Хуралд танилцуулах гэсэн ийм үндсэн үүрэг даалгавартайгаар байгаа.

Ингээд энэ ажлын хэсэг маань 2023 оны 11 сарын 10-ны өдөр бас өнөөдөр хуралдаж, “Нийтийн өргөдлийн талаарх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг ингээд санаачилж, Төсвийн байнгын хороонд танилцуулж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг та бүхэнд оруулж байна.

Та бүхэнд тогтоолын төслийг тараасан байгаа. Тогтоолын төслийг та бүхэнд би бас товчхон уншиж танилцуулъя.

1 дүгээрт, Цахим систем ашиглан иргэдийн оролцоог хангах, санал авах журмын дагуу ирүүлсэн нийтийн өргөдлийн үр дүнд үндэслэн иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын нэмэгдсэн өртгийн албан татвар болон татварын орчинд үнэлэлт, дүн шинжилгээ хийж, шударга ёсны зарчимд нийцүүлэн татварын орчныг боловсронгуй болгох санал, дүгнэлтээ Монгол Улсын Их

Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Төсвийн байнгын хороонд даалгасугай.

2.Энэ тогтоолын заалтад заасан асуудлаар шаардлагатай мэдээ мэдээллээр шуурхай хангаж ажиллахыг Монгол Улсын сайд, Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд Хүрэлбаатар, Монгол Улсын Сангийн сайд Жавхлан нарт даалгасугай гэсэн ийм 2 заалтай.

3 дахь заалт нь, Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө гэсэн ийм 3 заалттайгаар Улсын Их Хурлын тогтоолын төслийг бас та бүхэнд танилцуулж байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Нэрсийг авъя. Даваасүрэн гишүүн тасаллаа. Даваасүрэн гишүүний микрофоныг өгье.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Тэгээд энэ маань нөгөө НӨАТ-ын хувийг бууруулах тухай асуудал гэж ойлгоод байгаа шүү дээ, тийм биз дээ, тийм ээ. Тэгэхээр энэ, тийм буцаан олголт. Тэгэхээр би энэ асуудлыг ер нь бол нэг тийш нь болгох нь зүйтэй гэж бодож байна. Нийгэм 2 талтай болчихоод байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр 2 талын яриад байгаа зүйл дээр бол хоёуланд нь үндэслэл бий. Мэдээж хэрэг татварын хэмжээг үнэ буцаан олголт 50 хувь болохоор 5 хувиар буурна гэсэн үг. Энэ чинь юу гэсэн үг вэ гэвэл 2,6 их наяд байгаа байх, энэ дотоодын нэмэгдсэн өртгийн албан татвар орж байгаа орлого бол. Тэгэхээр 1 их наяд гаруй төгрөгийг буцааж олгох гэж байна гэсэн үг шүү дээ. Тэр талаас нь нэг хэсэг нь бол төсвийн орлого яах вэ гэдэг асуудал ярьж байгаа.

Нөгөө нэг хэсэг нь юу гэж ярьж байгаа вэ гэвэл энэ чинь татварын орлогоо нууж байгаа ялангуяа томоохон хэмжээний импорт хийж байгаа, тэгээд дараа нь нөгөө жижиглэнгийн

худалдаанд оруулахдаа татвараа нууж байгаа томоохон татвар төлөгчдийн орлогыг илрүүлснээр буцаагаад 1 их наядоос илүүг олно гэж ингэж ярьж байгаа. Нэг ёсондоо татвар нууж байгаа байдлыг ил болгох гэж байна л гэсэн үг биз дээ. Томоохон импортлогч нарын буюу бас ер нь импортлож байгаа улсуудын. Одоо бид нарт амьдрал дээр тулгардаг шүү дээ. Нөгөө НӨАТ-ын надаан авах уу, авахгүй юу гээд И-баримт бүрдүүлэх үү, бүрдүүлэхгүй юу гээд байгаа асуудлыг чинь цэгцэлье.

Тэгэхээр татвар нууж байгаа асуудал бол ил болно. Ингэснээр тэр нөгөө 5 хувиар буурч байгаа орлогоос илүү орлого олно гэдэг ийм 2 маргаан нийгэмд байгаад байгаа юм. Тэгээд үнэхээр татвар нууж байгаа нь үнэн бол үндэстэй ингэж тооцоотой хандаж байгаа нь үнэн бол магадгүй тэр 5 хувиар нь тэгээд бууруулаад ингээд ил тод болгоод буцаан олголтыг нь нэмэгдүүлснээр гараад ирж байгаа бол сайн хэрэг. Тэгэхээр энийг нягтлах ёстой. Би тэрэнтэй холбогдуулж энэ тогтоолыг гаргаж байна гэж ойлгож байна. Тэгэхээр нийгмийн энэ 2 тал болчихсон байгаа энэ асуудлыг нэг талд нь ингэж шийдэх нь зүйтэй.

Бууруулсан татварыг буцаан олголтоор буурсан татварыг нуусан татварыг ил болгосноор нөхнө өө гэдэг асуудлыг нэг талдаа шийдэх нь зүйтэй гэсэн. Би ийм саналтай байгаа.

Г.Тэмүүлэн: Даваасүрэн гишүүн санал хэллээ.

Тэгэхээр би бас товч нэмээд мэдээлэл өгье. Энэ Улсын Их Хурлын тогтоолын төсөл орж ирж байгаа маань 2 кодоор буюу энэ 2 дугаартай нийтийн 2 өргөдөл ирсэн. Нэгдүгээрх нь эхнийх нь, нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой иргэдээс гаргасан нийтийн өргөдөл байгаад байгаа. Хоёрдугаарх нь бол хувь хүний орлогын албан татвар болоод нийгмийн

даатгалын шимтгэлтэй холбоотой өргөдөл сая ирсэн байгаа. Тэгэхээр энэ асуудалтай уялдуулаад энэ иргэд бид өөрсдөө саналаа гаргаж, энэ татвартай холбоотой, нийгмийн даатгал шимтгэлтэй холбоотой байр сууриа илэрхийлж, энэ асуудлыг нухацтайгаар судалж, энэ дээр бодлого шийдвэр шаардлагатай бол гаргаач ээ гэсэн хүсэлтийг иргэд өргөдлөөр гаргаж ирж байна гэж харж байгаа.

Тэгэхээр манай Байнгын хорооноос байгуулагдсан ажлын хэсэг энэ асуудал дээр энэ иргэдээс гаргаж байгаа энэ 3 татвар болоод нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудал. Мөн дээрээс нь ерөнхийдөө энэ томоор нь татварын суурь эрх зүйн орчин, татварынхаа тогтолцоо дээр томоор нь үнэлэлт, дүгнэлт өгье. Бүх салбар болгоноор нь үнэхээр татварын ачаалал байгаа бол ачааллыг нь судлаад үзье. Ингээд бид нар бүр шаардлагатай бол татварын шинэчлэл хийх ч гэдэг юм уу, энэ саналаа Улсын Их Хуралд энэ Улсын Их Хурлын намрын чуулганы хугацаанд оруулж ирж, судлаад бодитоор үнэлэлт, дүгнэлт өгсний үндсэн дээр таны хэлсний дагуу нягталсны үндсэн дээр тооцоо судалгаан дээр суурилсан бодлогын төслийг бодлогын баримт бичгийг оруулж ирье гэсэн энэ чиглэлийг Улсын Их Хурлаас авъя гэсэн ийм тогтоолын төсөл байгаа гэдгийг танд хэлэх байна.

Гишүүд тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асууж дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд тогтоолын төслийг хэлэлцэхийг нь дэмжье гэдгээр санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал хураалтын дүнг танилцуулъя. Санал хураалтад 11

гишүүн оролцож, 90,9 хувиар дэмжигдлээ.

Ингээд тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд миний бие танилцуулъя.

Ингээд тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан дууслаа.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ